



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 04 сарын 19 өдөр

Дугаар A - 104

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны системд нөлөө бүхий банкийг тогтоох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан), Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН



14 0621

Монголбанкны Ерөнхий нөгчийн
2021 оны 4 дугаар сарын 19-ны өдрийн
4-104 дугаар түвшиний хавсралт



БАНКНЫ СИСТЕМД НӨЛӨӨ БҮХИЙ БАНКИЙГ ТОГТООХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20-д заасан “Банкны системд нөлөө бүхий банк”-ийг тогтооход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. “Банкны системд нөлөө бүхий банк” гэж банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дунд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкаас тогтоосон банкийг хэлнэ.

Хоёр. Банкны систем дэх нөлөөг тооцох

2.1. Банкны нөлөө бүхий байдлыг дараах хүснэгт дэх хүчин зүйл, үзүүлэлтийг үндэслэн тооцно:

Хүснэгт I. “Банкны системд нөлөө бүхий банк”-ийг тогтоох хүснэгт

Хүчин зүйл	Хүчин зүйлийн жин	Үзүүлэлт	Үзүүлэлтийн жин	Үзүүлэлтийн оноо
Хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ	(100%)/3	Нийт актив, цэвэр хүлээж болзошгүй үүргийн хэмжээ	Хүчин зүйлийн жин/1	Үзүүлэлтийн жин * [Үзүүлэлт (банкны)] [∑ Үзүүлэлт (системийн)] * 10,000
Санхүүгийн тогтолцоо дахь хамаарал	(100%)/3	Бусад санхүүгийн байгууллагаас авах авлагыг (Монголбанкны авлагыг цэвэршүүлсэн дүнгээр)	Хүчин зүйлийн жин/3	Үзүүлэлтийн жин * [Үзүүлэлт (банкны)] [∑ Үзүүлэлт (системийн)] * 10,000
		Бусад санхүүгийн байгууллагад өгөх өглөг	Хүчин зүйлийн жин/3	Үзүүлэлтийн жин * [Үзүүлэлт (банкны)] [∑ Үзүүлэлт (системийн)] * 10,000
		Бусад эх үүсвэр	Хүчин зүйлийн жин/3	Үзүүлэлтийн жин * [Үзүүлэлт (банкны)] [∑ Үзүүлэлт (системийн)] * 10,000
Үндсэн үйл ажиллагаа	(100%)/3	Иргэдэд олгосон актив – зээлдэгчийн тоогоор	Хүчин зүйлийн жин/6	Үзүүлэлтийн жин * [Үзүүлэлт (банкны)] [∑ Үзүүлэлт (системийн)] * 10,000
		Том ААН-д олгосон актив –	Хүчин зүйлийн жин/6	Үзүүлэлтийн жин * [Үзүүлэлт (банкны)] [∑ Үзүүлэлт (системийн)]

Хүснэгт 1. “Банкны системд нөлөө бүхий банк”-ийг тогтоох хүснэгт

Хүчин зүйл	Хүчин зүйлийн жин	Үзүүлэлт	Үзүүлэлтийн жин	Үзүүлэлтийн оноо
	зээлдэгчийн тоогоор			* 10,000
	Жижиг, дунд ААН-д олгосон актив – зээлдэгчийн тоогоор	Хүчин зүйлийн жин / 6	Үзүүлэлтийн жин * $\frac{\text{Үзүүлэлт (банкны)}}{\sum \text{Үзүүлэлт (системийн)}}$	* 10,000
	Татан төвлөрүүлсэн эх үүсвэр (харилцагчийн тоогоор)	Хүчин зүйлийн жин / 6	Үзүүлэлтийн жин * $\frac{\text{Үзүүлэлт (банкны)}}{\sum \text{Үзүүлэлт (системийн)}}$	* 10,000
	Орон нутаг дахь үйл ажиллагаа	Хүчин зүйлийн жин / 6	Үзүүлэлтийн жин * $\frac{\text{Үзүүлэлт (банкны)}}{\sum \text{Үзүүлэлт (системийн)}}$	* 10,000
	Төлбөрийн систем дэх гүйлгээний нийт тоонд эзлэх хувь	Хүчин зүйлийн жин / 6	Үзүүлэлтийн жин * $\frac{\text{Үзүүлэлт (банкны)}}{\sum \text{Үзүүлэлт (системийн)}}$	* 10,000
Банкны нөлөө бүхий байдлын оноо				Үзүүлэлтийн онооны нийлбэр

2.2. Банкны системд нөлөө бүхий банкийг тодорхойлох шалгуурын хүчин зүйл болон хүчин зүйлийн жинг тогтоохдоо дотоодын эдийн засаг, банк, санхүүгийн салбарын хүрээнд тухайн банк татан буугдаад үүсэж болзошгүй нөлөөллийн хэмжээг үнэлэх зарчмыг баримтална. Уг үнэлгээнд аливаа банк татан буугдаад банкны харилцагч, бусад банк, санхүүгийн байгууллагад учрах шууд болон шууд бус хохирол, эрсдэл, тухайн банкийг богино хугацаанд хүндрэл багатайгаар татан буулгах бололцоо, банкны салбарын тухайн үеийн онцлог шинж чанар болон бусад ач холбогдол бүхий хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

2.3. Банкны системд нөлөө бүхий банкийг тодорхойлох хүчин зүйлийг оновчтой илэрхийлэх шалгуур нь үзүүлэлт бөгөөд хүчин зүйлийн зорилготой нийтгэй байх, оор бусад хүчин зүйлд давхар тооцогдохгүй байх, үзүүлэлтийг хэмжих нэгж нь хүчин зүйлийг хэмжих нэгжтэй ижил байх зарчмыг баримтална.

2.4. Банкны системд нөлөө бүхий банкийг тодорхойлох хүчин зүйлийн оноог тооцоходоо хүчин зүйлд харгалзах үзүүлэлт тус бүрийн банкны системд эзлэх хувийг “банкны системд нөлөө бүхий банк”-ийг тогтоох хүснэгт дэх “үзүүлэлтийн жин (2)”-д үржүүлж, нийлбэрийг 10,000-д үржүүлэн тооцно.

2.5. Банкны нөлөө бүхий байдлын оноог энэ аргачлалын 2.4-д заасны дагуу тооцсон хүчин зүйлийн нөлөө бүхий байдлын онооны нийлбэр дүнгээр тооцно.

2.6. Энэ аргачлалын 2.1-д заасан хүчин зүйлийг дараах байдлаар хэмжинэ:

2.6.1. “Хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ” хүчин зүйл нь банкны үйл ажиллагаа, банкны бусад этгээдтэй байгуулсан бүх төрлийн хэлцэл, хүлээсэн эсхүл хүлээж болзошгүй үүргийг мөнгон дүнгээр хэмжинэ:

2.6.1.1. “Нийт актив, цэвэр хүлээж болзошгүй үүргийн хэмжээ” үзүүлэлтийг банкны тэнцлийн “Нийт актив”, болон тэнцлийн гадуурх “Цэвэр хүлээж болзошгүй үүрэг” тус бүрийн нийлбэрээр хэмжинэ.

2.6.2.“Санхүүгийн тогтолцоо дахь хамаарал” хүчин зүйл нь банкны бусад банк, санхүүгийн байгууллагатай холбоотой байдлыг мөнгөн дүнгээр хэмжинэ:

2.6.2.1.“Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага (Монголбанкны авлагыг цэвэршиулсэн дүнгээр)” үзүүлэлтийг бусад дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авах банкны авлагын нийлбэр дүнгээс Монголбанкны авлагыг (төгрөгийн авлага) хассан дүнгээр;

2.6.2.2.“Бусад санхүүгийн байгууллагад өгөх өглөг” үзүүлэлтийг бусад дотоодын банк, санхүүгийн байгууллагад өгөх банкны өглөгийн нийлбэр дүнгээр;

2.6.2.3.“Бусад эх үүсвэр” үзүүлэлтийг банкны тэнцэл дэх “Бусад эх үүсвэр”-ийн дүн.

2.6.3.“Үндсэн үйл ажиллагаа” хүчин зүйл нь банкны үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээг мөнгөн бус дүнгээр хэмжих зорилготой байна. Энэхүү хүчин зүйл нь дараах үзүүлэлт бүхий бүрэлдэхүүнтэй байна:

2.6.3.1.Банкны иргэдэд олгосон актив – нийт зээлдэгчдийн давхардаагүй тоогоор;

2.6.3.2.Банкны том аж ахуй нэгжид олгосон актив – нийт зээлдэгчдийн давхардаагүй тоогоор;

2.6.3.3.Банкны “Дунд аж ахуйн нэгж”, “Жижиг үйлдвэр эрхлэгч ААН”-д олгосон актив – нийт харилцагчдын давхардаагүй тоогоор;

2.6.3.4. “Татан төвлөрүүлсэн эх үүсвэр” үзүүлэлтийг банкны нийт хадгаламж болон харилцах данс эзэмшигчдийн нийлбэр – нийт харилцагчдын давхардаагүй тоогоор;

2.6.3.5. “Орон нутаг дахь үйл ажиллагаа” үзүүлэлтийг банкны салбар нэгж, тооцооны төв, касс, төлөөлөгчийн газрын тоогоор;

2.6.3.6. “Толборийн систем дэх гүйлгээний нийт тоонд эзлэх хувь” үзүүлэлтийг банкны их дүнт болон бага дүнт гүйлгээний RTGS системээр сүүлийн нэг жилийн хугацаанд амжилттай хийгдсэн гүйлгээний тоо, Үндэсний цахим гүйлгээний төвийн картын нэгдсэн сүлжээгээр сүүлийн нэг жилийн хугацаанд амжилттай хийгдсэн гүйлгээний тоо тус бүрийн нийлбэр.

ЖИШЭЭ: Банкны системд “А” банк, “Б” банк гэх хоёр банк байдаг гэж төсөөлье. “А” банкны үзүүлэлт, банкны нөлөө бүхий байдлын онооны тооцооллыг дараах хүснэгтээс үзнэ үү. Доорх хүснэгт дэх “Үзүүлэлтийн жин”-г Хүснэгт 1-д заасны дагуу тооцсон.

Хүснэгт 2. "A" банкны нөлөө бүхий байдлын тооцоолол.

Хүчин зүйл	Үзүүлэлт	Үзүүлэлтийн жин	"А" банк	"Б" банк	"А" банкны системийн %	Үзүүлэлтийн оноо
Хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ	Нийт актив, цэвэр хүлээж болзошгүй үүргийн хэмжээ	33.3%	70	30	70/100 =70%	33.3%*70% *10,000 =2,300.00
Санхүүгийн тогтолцоо дахь хамаарал	Банк, санхүүгийн байгууллага хоорондын авлагын хэмжээ (Монголбанкны авлагыг цэвэршүүлсэн дунгээр)	11.1%	10	10	10/20 =50%	11.1%*50% *10,000 =550.00
	Банк, санхүүгийн байгууллага хоорондын өглөгийн хэмжээ	11.1%	10	15	10/25 =40%	11.1%*40% *10,000 =400.00
	Бусад эх үүсвэр	11.1%	0	0	0%	0.00
Үндсэн үйл ажиллагаа	Иргэдэд олгосон актив – зээлдэгчийн тоогоор	5.6%	25	15	25/40 =62.5%	5.6%*62.5% *10,000 =347.22
	Том ААН-д олгосон актив – зээлдэгчийн тоогоор	5.6%	0	0	0%	0.00
	Жижиг, дунд ААН-д олгосон актив – зээлдэгчийн тоогоор	5.6%	5	5	5/10 =50%	5.6%*50%* 10,000 =277.78
	Татан төвлөрүүлсэн эх үүсвэр (харилцагчийн тоогоор)	5.6%	70	30	70/100 =70%	5.6%*70%* 10,000 =388.89
	Орон нутаг дахь үйл ажиллагаа	5.6%	0	0	0%	0.00
	Төлбөрийн систем дэх гүйлгээний нийт тоонд эзлэх хувь	5.6%	50	30	50/80 =62.5%	5.6%*62.5% *10,000 =347.22
Банкны нөлөө бүхий байдлын оноо						4,611.11

Гурав. Банкны системд нөлөө бүхий банкийг тогтоох

3.1.Банкны нөлөө бүхий байдлын оноогоор 500 болон түүнээс дээш оноо авсан банкийг "банкны системд нөлөө бүхий банк" гэж тогтооно.

3.2.Энэ аргачлалын 3.1-д заасан босго оноог тухайн үеийн эдийн засаг, банк, санхүүгийн салбарын нөхцөл байдлыг харгалзан өөрчилж болно.

3.3.“Банкны системд нөлөө бүхий банк”-ны босго оноог өөрчилсөн бол өөрчлөх болсон шалтгаан, үндэслэлийг олон нийтэд мэдээлнэ.

3.4.Энэ аргачлалын 3.1-д заасны дагуу Монголбанкны банкны бодлого, зохицуулалт чиг үүрэг бүхий газар нь банкны нөлөө бүхий байдлын оноог банк тус бүрээр жилд нэгээс доошгүй удаа тооцоолно.

3.5.Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бол “банкны системд нөлөө бүхий банкны жагсаалт”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар шинэчлэн баталж, олон нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Бусад

4.1.Энэ аргачлалыг Монголбанкны банкны бодлого, зохицуулалтын чиг үүрэг бүхий газар жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай тохиолдолд аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж шийдвэрлүүлнэ.

---oOo---